



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 02 өдөр

Дугаар

А/145

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.4, 18.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл 27.6, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1, 30.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/847, 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/244 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн 2025 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох 1 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 1 хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 3 хуулийн этгээдийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон болон хүчингүй болсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (М.Навчаа), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д тус тус даалгасугай.

4. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/16 дугаар тушаалын "Болор Сондор" ХХК, дүүргийн Засаг даргын 2024 оны А/221 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын "Дорнын соёл" ХХК, 2024 оны А/290 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын "Парти Кингс" ХХК-ийн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010463

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн
... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт




СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Гоожуурын Хүрхрээ ХХК	С.Гантулга	Гоожуурын Хүрхрээ	6595952	Хүнсний дэлгүүр	06:00-00:00	21	Булгийн 20-1237в тоот

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Жи Ди Ай ХХК	О.Батпүрэв	Классик	5398541	баар/караоке	14:00-04:00	2	2 дугаар 40 мянгат гудамж 20 дугаар байр 20 тоот



Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Хороо	Хаяг, байршил	Тайлбар
1	Болор Сондор ХХК	Ж.Чулуунцэцэг	2828316	Хүнсний дэлгүүр	18	Яргайтын 41-640в тоот	Үйл ажиллагааг зогсоож, хүчингүй болгох хүсэлт гаргасан
2	Дорнын соёл ХХК	Н.Нэмэхбаяр	2565293	ресторан	4	Бага тойруу 9 байр 3 тоот	Үйл ажиллагааг зогсоож, хүчингүй болгох хүсэлт гаргасан
3	Партикингс ХХК	Ц.Батбаатар	5324572	диско/баар	6	Их тойруу Засгын газрын авто бааз ТӨААТҮГ-н гадна залгаа	Цагдаагийн газраас ирүүлсэн саналын дагуу